



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/А62

Булган сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.9, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны XIX/08 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын 1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бугат сумын Хужирын адгийн гарам, Хүүшийн хорооны гүүрний засварын ажилд 30,000,000 (гучин сая) төгрөгийг зарцуулах эрхийг Бугат сумын Засаг дарга (Х.Ууганбаяр)-д олгосугай.

2. Орон нутгийн чанартай авто зам засварын ажилд зарцуулах эрх олгогдсон хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зохион байгуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, зарцуулан тайлагнахыг Бугат сумын Засаг дарга (Х.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

3. Дээрх ажлыг гүйцэтгэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээнд батлагдсан "Орон нутгийн чанартай авто замын засвар, арчлалт" зардлаас санхүүжүүлэхийг төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Сайнзаяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР

